



ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А122

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газрын захирлын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны 249 тоот тушаалаар баталсан "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам"-д дор дурдсанаар нэмэлт өөрчлөлт оруулсугай.

1/ 2.2 дахь хэсгийн "...стандартын дагуу мөрдөн ажиллана." гэснийг "стандартын дагуу үзүүлнэ.";

2/ 4.1 дэх хэсгийн "... хоёрдугаар хавсралтад тусгав." гэснийг "хавсралтад тусгав."

3/ "4.2. Анхан шатны тусламж үйлчилгээнд шаардлагатай эмийн жагсаалтыг захиалгын хуудсаар захиалах бөгөөд худалдаж авсан үнэ дээр тавин хувь нэмж эмийн үнийг тогтооно." гэсэн заалт нэмсүгэй.

2. Журмын хавсралтаар батлагдсан "Эмчийн үзлэг, эмчилгээний үнэ тариф"-д тусгагдсан дусал тариаг 2000 төгрөг, судас, булчин тариа хийх 1000 төгрөг, тархины доргилтын бариаг 5000 төгрөг байхаар тус тус өөрчлөн баталсугай.

3. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан 2017 оны 11-р сарын 15-ны 249 тоот тушаалын гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.


4. Тушаалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг Үйлчилгээний хэлтэс (Б.Эрдэнэбаяр), Санхүү, бүртгэлийн хэлтэс (Д.Мөнхтуяа)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ө.ЛУВСАНРЕНЧИН

Засгийн газрын байруудын нийтлэг
үйлчилгээний газрын захирлын
2022 оны 4 дугаар сарын 4-ны
өдрийн 44 тоот тушаалын хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

NUG-J-035

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газартай "Ажил үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан байгууллагуудын ажилтан, албан хаагчдын өвчин эмгэгийг үзэх, оношлох, эмчлэх, хүндрэлээс сэргийлэхэд чиглэгдсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхэд энэхүү журмыг баримтлана.

Хоёр. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх

2.1. Ажилтан, албан хаагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ёс зүйн хэм хэмжээг баримтлан, эмчийн өргөсөн тангарагтаа үнэнч байж, цаг алдалгүй хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй үзүүлж ажиллана.

2.2. Ажилтан, албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эмчилгээний стандартын дагуу үзүүлнэ.

Гурав. Анхан шатын болон яаралтай тусламж үйлчилгээ, уламжлалт эмчилгээ үзүүлэх

2.1. Эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламж үзүүлэх шаардлага тулгарсан тохиолдолд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай, яаралтай үзүүлж дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэж ажиллах.

2.2. Эмнэлгийн анхан шатны болон яаралтай тусламжийн үед шаардагдах эм тариа, туслах материалын чанар, аюулгүй байдал, хүчинтэй хугацаанд байнгын хяналт тавьж ажиллах.

2.3. Уламжлалт анагаах ухааны оношлогоо, эмчилгээг чанартай гүйцэтгэж, халдвар хамгааллын дэглэмийг хатуу мөрдөж ажиллах.

Дөрөв. Эмчилгээ үйлчилгээний тариф

4.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон уламжлалт эмчилгээний үйлчилгээг байгууллагаас баталсан үнэ, тарифын дагуу төлбөртэй үзүүлэх бөгөөд үнийн тарифыг уг журмын хавсралтад тусгав.

4.2. Анхан шатны тусламж үйлчилгээнд шаардлагатай эмийн жагсаалтыг захиалгын хуудсаар захиалах бөгөөд худалдаж авсан үнэ дээр тавин хувь нэмж эмийн үнийг тогтооно.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ
үзүүлэх журмын хавсралт

ЭМЧИЙН ҮЗЛЭГ, ЭМЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ

№	Эмчилгээний төрөл	Үнэ/төгрөг/	
1	Анхан шатны буюу яаралтай тусламж	Үнэгүй	
2	Зөвлөгөө өгөх, эмчилгээний жор бичиж өгөх	Үнэгүй	
3	Дусал тариа	2000	
4	Судас, булчин тариа хийх	1000	
Уламжлалт эмчилгээ			
№	Үйлчилгээний төрөл	Эмчлэх хугацаа	Үнэ/төгрөг/
1	Зөгийн балтай татлага		3000
2	Хэсэгчилсэн бариа (толгой, хүзүү, сэрвээ, нуруу) бумба	20-30 минут /тухайн хүний өвчний байдлаас хамаарна/	5000
3	Бумба тавих	15 минут	2500
4	Тархины доргилтын бариа		5000
5	Гулгуур бумба тавих		2500
6	Хордлого тайлах		1000
7	Шарлага /УВЧ/	Гэрлэн	2000
		УВЧ	1000
8	Төөнүүр		1500

Тайлбар: Тус байгууллагын ажилчид дээрх үнээс 50 хувийн хөнгөлөлттэй үйлчлүүлнэ.

ХҮЧИНТЭЙ